

МОНГОЛЫН ШИНЭ СЭТГҮҮЛ ЗҮЙГ ТҮҮХЧЛЭХ АСУУДАЛД

Б. Галаарид\*

\* МСЭ-ийн ерөнхийлөгч, докторант

**Түлхүүр үг:** шинэ сэтгүүл зүй, өөрчлөн байгуулалт, чөлөөт хэвлэл, "Шинэ толь" сонин, ардчилсан хөдөлгөөн

1980-аад оны эхний хагаст Монголын сэтгүүл зүйн чиг хандлага, өнгө төрхийг нам засгийн төв хэвлэл "Үнэн" сонингоор төлөөлүүлэн үзэж болно. Үндэсний сэтгүүл зүйн нэрт төлөөлөгч Л.Түдэв 1984 оны эцсээр тус сонин ерөнхий эрхлэгчээр томилогдож, дараа оноос нь эхлэн нийтлэлийн бодлогодоо эрс өөрчлөлт хийж эхэлсэн нь тодорхой байна.

Энэ нь социалист системийн гол чиглүүлэгч гүрэн болох ЗХУ-д өөрчлөн байгуулалт, ил тод байдал хүчээ авч эхэлсэн улс төрийн гадаад нөхцөл байдалтай эн тэргүүнд холбоотой гэмээр байна. Тэр үеийн "Үнэн" сонин нийтлэлүүд, тэнд ажиллаж байсан сэтгүүлчдийн дурсамж, судлаач эрдэмтдийн бүтээл зэргийг нягтлан шинжилж үзэхэд «Тэр үеийн "Үнэн" сонин асуудалд хандах шинэлэг хандлага, далайцын хувьд ЗХУ-д өрнөж буй перестройка-гийн уур амьсгалаас бага зэрэг хоцрогдонгуй ч тэр үед төрийн эрхийг дангаар барьж байсан МАХН-ын Төв хорооноос

хавьгүй түрүүлж байсан нь олон баримтаар нотлогдож байна. Энэ нь бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийн бодлогод ч тусгалаа олж, Монголын сэтгүүл зүй олон өнгөөр дуугарах эхлэл тавигдаж эхэлсэн гэж хэлж бас болно»<sup>1</sup> гэсэн дүгнэлт гарч байна.

ЗХУ-д 1987 оны 1-р сараас өөрчлөн байгуулалтын хоёрдугаар үе шат эхэлж, оршин буй нийгмийн тогтолцооныхоо гажгийг эрс хурцаар шүүмжилж эхэлсэн. Харин Монголд ингэж нээлттэй шүүмжлэх бололцоо харьцангуй хаагдмал байсаар 1989-1990 оны ардчилсан хувьсгалтай золгосныг нотлох баримт олон байна. Тухайлбал, 1987 оны 11-р сарын 15-нд МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Батмөнх "Үнэн" сонин зөвлөлийнхнийг хүлээн авч, заавар зөвлөгөө өгчээ. Тэгэхдээ "Намын сонин учир намын үгийг хэлж байх, Монгол-Зөвлөлтийн найрамдал, социалист байгуулалтын ололтыг бататгах чиглэл баримтлахыг голлон яриу" гэж тухайн үеийн "Үнэн" сонин ерөнхий эрхлэгч Л.Түдэв тэмдэглэн үлдээсэн байна. Энэ бол тухайн цаг үед хэвлэл мэдээллийн хэрэгсэл юуг хэрхэн, ямархуу хил хязгаартайгаар бичиж мэдээлэх талаар төрөөс өгсөн үүрэг даалгавар юм.

Монголын радиогоор 1988 оны 8-р сарын 21-ний өдөр сэтгүүлч Нанж.Лхагвын "Монгол ган" нэвтрүүлэг цацагдсан бөгөөд ган төмөр эдлэлээ өөрсдөө хийж чаддаг байсан монголчууд үндэсний үйлдвэрлэлээ орхиж, бүх зүйлийг Оросоос голдуу авдаг хараат улс болсныг шүүмжилсэн нь Монгол-Зөвлөлтийн найрамдалд харш мэдээлэл түгээсэн хэрэг болон хувирч, МАХН-ын Төв хорооны үзэл суртлын хэлтэс энэ асуудлыг олонтаа хэлэлцэн, сэтгүүлчийг шоронд хийх эсэхдээ тулсан байна. Энэ талаар сэтгүүлч Нанж.Лхагва «Намайг энэ асуудалд ороогдон байдал бишдээд эхэлмэгц "Үнэн" сонины эрхлэгч Л.Түдэв дуудаад "Чи тэр нэвтрүүлгээ сонины нийтлэл болгоод аваад ир" гэж үүрэг өгсөн. Хэлснийх нь дагуу нийтлэл болгож бичээд очтол "Үнэн" сониндоо гаргаж өгсөн. Мөн оросоор орчуулагдан "Новости Монголии" сонинд нийтлэгдсэн»<sup>3</sup> гэж дурссан байна. Асуудлыг ийнхүү олон нийтийн анхаарлын төвд яаралтай оруулж нууцлах аргагүй болгосон, мөн "Үнэн" сонины нэр хүндийг ашигласнаар Нанж.Лхагва ял зэмгүй үлдсэн болохоос биш нөхцөл байдал хавьгүй ээдрээтэй байж мэдэхээр байжээ.

**Э**нэ үеэр жинхэнэ утгаар нь чөлөөт хэвлэл гаргах оролдлого хийсэн "Цагийн толь" сонин тэргүүн нүүртээ зохиолч Д.Нацагдоржийн зурмал хөргийг байршуулж, дор нь "Гагцхүү нарыг хэвээр үлдээмэй" гэж түүний шүлгээс эшлэсэн нь юу хэлж, юунд уриалаад байна вэ гэсэн хардлага сэрдлэг дагуулж Нийгмийг аюулаас хамгаалах яам үүрэг өгч тус сониныг хаасан нь тухайн үеийн нийгмийн тогтолцоог хүчтэй шүүмжлэх

нөхцөл хараахан бүрдээгүй байсны нотолгоо юм. Гэхдээ энэ нь чөлөөт хэвлэлийн үзэл санааг Монголд түгээн дэлгэрүүлэх оролдлого тэр үед огт байгаагүй гэсэн үг биш бөгөөд шинэчлэлийг хүсэгч олон хүн энд тэндгүй үзэл бодол, хүсэл сонирхлоороо нэгдэж байсан бөгөөд тэдний нэг болох "Шинэ үе" бүлгэм гэхэд л НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг олон нийтэд ил болгохыг уриалсан ухуулах хуудас нууцаар тарааж байсан нь иргэдийн мэдэх эрх, мэдээлэл олж авах эрхийг дээдлэх асуудал хөндөгдөж эхэлсний илэрхийлэл юм.

1989 оны 12-р сарын 10-нд Улаанбаатарт болсон МоАХ-ны анхны цуглаанаас гаргасан баримт бичигт ч чөлөөт хэвлэлийн асуудал тусгалаа олсон нь шинэ сэтгүүл зүй буюу чөлөөт сэтгүүл зүй хөгжих цаг ойртсоныг дохиолжээ.

1990 оноос янз бүрийн нам хөдөлгөөний нэр дор харьцангуй чөлөөт хэвлэлүүд олноороо гарч эхэлсэн бөгөөд тэдгээрийн анхдагч нь "Шинэ толь" сонин юм. Ийм нэртэй сонин гаргах асуудал 1990 оны 1-р сарын 6-ны өдөр МоАХ-ны Ерөнхий зохицуулах зөвлөлийн гишүүдийн ээлжит уулзалтын үеэр яригдаж шийдэгдсэнийг түүхэн баримтууд нотолж байна. Монголын шинэ сэтгүүл зүйн түүхэнд заавал тэмдэглэгдэх ёстой энэ хурал МУИС-ийн криминалистикийн лабораторид болсон байна.

Ардчиллын анхны 13-ын нэг, сэтгүүлч С.Амарсанаа энэ хурлын тухай дурсахдаа «Сонинтой болох тухай асуудлыг хэлэлцэхэд нэг сэтгүүл, нэг сонинтой больё гэсэн санал гарлаа. Би сониндоо "Шинэ үе" гэж нэрлэх санал гаргав. Тэгтэл Дарь.Сүхбаатар "Цагийн

толь" гэж нэрлэх санал гаргав... Ингээд хэсэг ярилцаж зөвлөлдсөний дараа "Шинэ үе"-ийн эхний үгийг, "Цагийн толь"-ийн сүүлийн үгийг авч нийлүүлээд "Шинэ толь" гэж нэрлэхээр шийдлээ<sup>4</sup> гэсэн байна.

«Ардчилсан үйл явцын эхэн үе дэх анхны сонин бол 1990 оны 2 сараас эхэлсэн ШИНЭ ТОЛЬ юм. 1988 оны мөнөөх хаагддаг "Цагийн толь"-иос "толь"-ийг нь аваад, С.Цогтсайхан нарын 1989 оны 1-р сард гудамжинд наасан ухуулах хуудасныхаа доор бичсэн "Шинэ үе" гэдэг үгээс "Шинэ"-ийг аваад сэтгүүлч С.Амарсанаа бид хоёрын өгсөн нэр юм шүү дээ. Эрхлэгчээр нь С.Баяр (С.Зоригийн ах) ажиллаж байсан»<sup>5</sup> гэж 1989 онд Монголд өрнөсөн ардчилсан хөдөлгөөнийг үүсгэн санаачлагчдын нэг Дарь.Сүхбаатар 2013 оны 1-р сарын 22-нд үүнийг бичигчид илгээсэн цахим захидалдаа дурссан нь С.Амарсанаагийн бичсэнтэй яв цав таарч байна.

“Шинэ толь” сонин үүсэн бий болсон түүхтэй холбоо бүхий хүмүүстэй уулзаж сурвалжлан нягтлах явцад тус сонин нэр нь 1913 онд Монголын сэхээтнүүд анх удаа бие даан гаргасан “Шинэ толь хэмээх бичиг” сонин нэртэй ямар нэг холбоогүй, залгамж чанаргүй, ийм адил төстэй нэр өгсөн нь цэвэр тохиолдол болох нь батлагдаж байгаа бөгөөд түүхийг “уран сайхан-жуулах” үүднээс ийм яриа гарч байгаа нь бодит үнэнийг гуйвуулсан хэрэг гэдгийг судлаачид анхааралдаа авбал зохино.

Ийм шинэ сонин хэвлэгдэн гарсныг МҮЭ-ийн Соёлын төв ордонд 1990 оны 2-р сарын 18-нд болсон МоАХ-ны анх-дугаар их хурлыг удирдаж байсан

сэтгүүлч Ц.Элбэгдорж хурлын индэр дээрээс зарлан мэдээлсэн түүхтэй.

МоАХ-ны ахмад зүтгэлтэн, “Дугуй заалны Оюунаа” гэх тодотголтой Тодын Оюунчимэг «Хурал эхлэхэд л ардчиллын дуу хоолой болсон “Шинэ толь” сонин эхний дугаар тараагдаж билээ. Энэ сонин миний дүү Отгонбаярын минь дотнын найз Нацагийн Жаргалсайхан макет загварыг хийгээд хэсэг нөхдийн хамт 17-ны шөнө хэвлүүлэн авчирч хурлын төлөөлөгчдийн сандал дээр тавьж байсныг сайн мэдэх юм»<sup>6</sup> гэж өөрийнхөө дурсамжийн номдоо өгүүлсэн нь “Шинэ толь”-ийн түүхэнд холбогдох чухал мэдээлэл юм.

“Ардчилал” сонин загвар дэглэлтийг хариуцаж байсан Ш.Мягмарсамбуу шинэ цагийн чөлөөт хэвлэлийн салхийг хагалсан “Шинэ толь” сонин талаар дурсахдаа “Тэр сонинг Шинжлэх ухаан мэдээллийн төвд ажиллаж байсан Тэрбиш, Эрдэнэбат зэрэг гурван залуугаар хийлгэсэн юм байна лээ”<sup>7</sup> гэж хэлсэн нь тухайн цаг үеийн үйл явдалд оролцож байсан олон хүний яриатай таарч байна.

Тодын Оюунчимэгийн дурсамжинд нэр гарч буй Н.Жаргалсайхан нь Ш.Мягмарсамбуугийн хэлж буй Шинжлэх ухаан, мэдээллийн төвд ажиллаж байсан гурван залуугийн нэг байж мэдэх бөгөөд энэ мэтээр судалж нягтлах олон асуудал эзнээ хүлээж байна.

“Шинэ толь” сонин АЗ форматын хоёр нүүрээр нийтдээ гучаад дугаар гараад үйл ажиллагаагаа зогсоожээ.

“Шинэ толь”-ийн араас “Ардчилал”, “Үг”, “Үндэсний дэвшил” зэрэг сонинууд шинээр байгуулагдаад буй нам, хөдөлгөөний харьяан дор мэт боловч хэрэг дээрээ харьцангуй чөлөөт маягаар

хэвлэгдэж эхэлсэн нь Монголын үндэсний сэтгүүл зүйн түүчээ болсон "Шинэ толь хэмээх бичиг" сонин 1913 онд мөн л бусдын нэр дор мэт боловч харьцангуй чөлөөтэй гарч байсан түүхийг давтсан хэрэг юм. 1990 онд Монголын чөлөөт хэвлэлийн хөрс суурь үндсэндээ бүрэлдэн бий болсон гэж дүгнэж болно. Ийм хөрс суурь бүрдэхэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн анхдагчдын нэг бол "Ардчилал" сонин юм. Энэ сонины анхны дугаар 1990 оны 4-р сарын 6-7-нд шилжих шөнө Улсын хэвлэлийн комбинатын Сонины хэвлэх үйлдвэрт А2 форматаар 4 нүүрээр хэвлэгдсэн байна.

Тус сониныг гардан хариуцаж байсан С.Амарсанаа

энэ сонины бодлого, байр суурийг хэрхэн томъёолж, ямар байр суурьтай байсан нь "Ардчилал" сонин МоАХ, МоАН-ын үзэл санааг түгээхээс гадна сэтгүүлчид, сэхээтнүүд үгээ зоригтой хэлэхэд зориулагдсан чөлөөт индэр болох учиртай. Сайн хэлж, уриалж, ухуулахгүй бол сэтгүүлчид маань шинэ үзэл санааг идэвхтэй дэмжихэд төдийлөн бэлэн биш байна"<sup>8</sup> гэж тухайн үедээ өдрийн тэмдэглэлд бичиж байснаас тодорхой байна.

Ийм нэр бүхий сонин хэвлэх асуудал 1990 оны эхнээс яригдсан бөгөөд МоАХ-ны ерөнхий зохицуулагч С.Зориг өөрийн төрсөн ах, "Новости Монголии" сонинд ажиллаж байсан С.Баяр, мөн сонины ажилтан Ш.Мяг-

марсамбуу нарт "Ардчилал" сонины анхны дугаарыг эрхлэн гаргах үүрэг өгсөн байдаг. Гэвч ажиллах хүн, хүч дутагдалтай, редакц бүрдүүлж чадаагүй болохоор ажил нь олигтой яваагүй байна. "Хоёрхон хүнээс чинь яаж ч өөдтэй сайн сонин гарах вэ дээ. Тэд нар материал өгнө гэсэн боловч байдаггүй. Тэр үед Ардчилсан холбооны зохицуулах зөвлөл хуралдав. Ху-

ралд нь бид сонингоо редакцийн бүтэцтэй болгож зохион байгуулаач гэж хүсэлт гаргав"<sup>9</sup> гэж "Ардчилал" сонины анхны макетыг хийсэн Ш.Мягмарсамбуу дурссан, анхны эрхлэгч С.Амарсанаа болохоор "Бүгд цаанаа үндсэн ажилтай учраас редакц

«

*"Шинэ толь" сонины нэр нь 1913 онд Монголын сэхээтнүүд анх удаа бие даан гаргасан "Шинэ толь хэмээх бичиг" сонины нэртэй ямар нэг холбоогүй, залгамж чанаргүй, ийм адил төстэй нэр өгсөн нь цэвэр тохиолдол болох нь батлагдаж байгаа бөгөөд түүхийг "уран сайханжуулах" үүднээс ийм яриа гарч байна.*

»

байхгүй, эрхлэн гаргах мэргэжлийн хүнгүй яваад байсан аж. Мягмарсамбуу сүүлийн хоёр удаагийн ЕЗЗ-ийн хуралд оролцож "Сониноо гаргах гэж байна. Хүн нэмж өгөөч" гэж нэхдэг байв"<sup>10</sup> гэж бичсэнээс үзэхэд тодорхой байна. Сэтгүүлч С.Амарсанаа "Хөдөлмөр" сонингоос халагдаж, "Ардчилал" сонинд ажиллахаар ирснээр албан ёсны редакц байгуулах нөхцөл бүрэлдэж, Монголын чөлөөт хэвлэлийн түүхэнд өөрийн гэсэн байр суурьтай энэ сонины үйл ажиллагаа жигдэрч эхэлжээ.

1990 оны 5-р сарын 1-нд АСХ, МСДН-ын хэвлэл "Үг" сонины анхны дугаар, мөн сарын 6-нд Шинэ дэвшилт холбоо, МҮДН-ын "Үндэсний дэвшил" сонин хэвлэгдсэн бол Чөлөөт

хөдөлмөрийн намын "Чөлөөт хөдөлмөр" сонины анхны дугаар мөн оны 5-р сарын 18-нд анх гарсан байна. Эдгээр болон 1990-ээд оны эхээр гарч байсан олон зуун сонины түүхийг бичиглэх, шинэ сонины давалгааныг үзэгдлийнх нь хувьд судлан шинжлэх цаг нэгэнт болоод байна.

Улс төрийн шинэ нөхцөл байдалд бэлтгэлгүй байсан Монголын төр эдгээр хэвлэлүүдтэй хэрхэн харьцах талаар тодорхой бодлого боловсруулж амжихгүй, бүртгэх хянах, журамлах талаар ямар нэгэн арга хэмжээ авалгүй зөнд нь орхисон бөгөөд төр өөрийн гэсэн хэвлэлтэй болж, түүгээрээ дамжуулан бодлогоо сурталчлах ганцхан арга зам бодож олсны үр дүн нь "Ардын эрх" сонин юм. Төрийн төв хэвлэл "Ардын эрх" сонины туршилтын дугаар 1990 оны 5-р сарын 9, анхны дугаар мөн оны 7-р сарын 1-нд тус тус гарчээ. Энэ нь МАХНам, Монгол төрийн хэвлэл хамтдаа байсан урьдын практикаас татгалзсан сайн талтай ч "Ардын эрх" нь төрийн шууд мэдлийн хэвлэл гэдэг утгаараа шударга өрсөлдөөнөөс ангид, гарааны огт өөр нөхцлөөс түүхээ эхэлсэн монополь хэвлэл болсноороо сөрөг талтай байв. Төрийн ивээл дор байдаг, албан ёсны чухал чухал мэдээллийн эх сурвалжид ойр, материаллаг бааз, боловсон хүчнээр давуу учраас "Ардын эрх"-тэй бусад сонинууд өрсөлдөх боломжгүй байлаа. Гэхдээ сэтгүүлчдийн ажлын арга барил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн үнэлэмжийг нэмэгдүүлэх тухайд "Ардын эрх" сонины удирдлагууд, тухайлбал ерөнхий эрхлэгч Ц.Балдорж онугуй анхаарч өөрийн гэсэн онцлогтой дэг (школа)-ийг бий болгож чадсан нь Монголын сэтгүүл

зүй, ялангуяа сонины сэтгүүл зүйд одоо ч өгөөжөө өгсөөр байна.

1990-ээд оны эхэн үед дуу дуугаа аван мэндэлсэн асар олон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дундаас онцлон судлууштай, Монголын сэтгүүл зүйн түүхэнд олон зүйлээр анхдагч болсон сонин бол Ү.Хүрэлбаатар эрхлэгчтэй "Улаанбаатар" юм. Улаанбаатар хотын АДХ, ЗДТГ-ын харьяа "Улаанбаатар" сонины туршилтын дугаар 1990 оны тавдугаар сарын 16, анхны дугаар нь мөн оны аравдугаар сард гарчээ. Тус сонин "Нүгэл буян", "Алтан босго", "Арга билиг", "Улаанбаатарын үдэш", "Алаг шаазгай", "Утга зохиол урлаг" зэрэг арав гаруй сониныг дагуул сонин хэлбэрээр эрхлэн гаргаж, шилжилтийн үеийн хамгийн хүнд цаг үеүдэд харьцангуй тогтвортой оршин тогтнож байсан түүхийг шинжлэх нь судлаачдын үүрэг юм.

Сэтгүүл зүйн салбарт 1990 онд гарсан онцлог боловч судлаачид төдийлөн анхааралгүй өдгөөг хүргэж буй бас нэг гол үйл явдал нь "Эрүүл энх" нэртэй хэвлэлийн газар юм. Тус хэвлэлийн газар эхлээд "Хүмүүн" нэртэй сонин эрхлэн гаргажээ. "Хүмүүн" сонины анхны дугаар 1990 оны 8-р сарын 11-нд хэвлэгдсэн бөгөөд №1 (154) гэж дугаарлагдсан нь учиртай байжээ. Тус сонины ерөнхий эрхлэгч Ч.Энхдалай энэ талаар бичихдээ «Таны дэлгэн уншихаар завдаж буй энэ сонин шинэ ч юм, бас ухруулан үзвэл хуучин ч гэж болно. Эрүүлийг хамгаалах яамнаас 1980-1982 онд хэвлэн нийтэлж байсан "Эрүүл энхийн төлөө" сонины 153 дугаар эдүгээ зөвхөн номын сангуудад үлдсэн. "Хүмүүн" сонин нэг талаас үүнийг залгамжлах учиртай»<sup>11</sup> гэж

тайлбарласан байдаг. “Хүмүүн” сонин-ноор гараагаа эхэлсэн “Эрүүл энх” хэвлэлийн газар “Өрх бүл”, “Охид хөвгүүд”, “Спортын ертөнц”, “Эрчүүд”, “Эмэгтэйчүүд” зэрэг арав шахам сэтгүүл эрхлэн гаргаж байв.

“Улаанбаатар” сонин тухайн үедээ дагуул сонинууд эрхлэн гаргаж, анхны медиагрупп үүсгэж байсан бол “Эрүүл энх” нь нийгмийн тодорхой бүлэг, тодорхой насныханд зориулсан багц сэтгүүл эрхлэн гаргаж байснаараа онцлог байна.

1990-ээд оны эхэн үеийн сэтгүүл зүйн хөгжлийг судлах явцад олсон бас нэг сонирхолтой баримт бол үндэсний өдөр тутмын чөлөөт сонин эрхлэн гаргах анхны оролдлого хаанаас эхтэй вэ гэх асуудал юм. Ардчиллыг баталгаажуулах үйл хэрэгт чөлөөт хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал үүрэгтэйг олж харсан “Ардчилал” сонин газар 1991 оны 12-р сарын 12-ны өдөр Хууль зүйн яамнаас “Сайн байна уу?” гэдэг өдөр тутмын сонин эрхлэн гаргах албан ёсны зөвшөөрөл авч анхны дугаараа 1992 оны 3-р сард гаргажээ. Хэдийгээр ийм сонин эрхлэн гаргах эрхийг “Ардчилал” сонин авсан ч анхнаас нь бие даасан чөлөөт байлгах эрмэлзэлтэй байжээ гэдэг нь дараах эшлэлээс харагдана.

“Сайн байна уу?” сонин эрхлэгч Ш.Мягмарсамбуу сонинхоо анхны дугаарт “Сайн байна уу? Та” гарчигтай мэндийн үг бичихдээ “Ардчиллын ачаар Монголд биеэ даасан, аль нэг байгууллагын бөөрөнд аваачиж наагаагүй хэвлэл бий болох зам нээгдэв. Урьд манайх нийт үндэстний биеэ даасан, өдөр тутмын сонинтой байсангүй. Одоо ч алга. Тиймээс “Ардчилал” сонин

хамт олон ийм нэгэн сонин эрхлэн үүсвэрийг тавих эрмэлзэл өвөрлөн “Сайн байна уу” сонинг та бүхэндээ толилуулж байна”<sup>12</sup> гэсэн нь үндэсний хэмжээний өдөр тутмын чөлөөт сонин бий болгох санаачилгыг “Ардчилал” сонинхоон 1991 онд сэдэж санаачилж, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд “Сайн байна уу” сонинг гаргажээ гэж дүгнэх боломж олгож байна.

Үндэсний хэмжээний хараат бус сонин эрхлэн гаргах дараагийн нэг том оролдлого нь Б.Батбаяр (Баабар)-ын “Өнөөдөр” юм. Энэ сонин анхны дугаар 1992 оны 10-р сарын 6-нд гарчээ. Аливаа сонин анхны дугаартаа өөрийн нийтлэлийн бодлого, зорилго чиглэлээ тайлбарладаг уламжлалыг даган ерөхий эрхлэгч Баабар “Уншигч танд учирлах нь” гэсэн гарчигтай өгүүлэл бичиж, сүүлийн хоёр жилийн хугацаанд олон ургальч хэвлэлүүд бий болсон боловч аливаа мэдээллийг хэнээс ч үл хамааран чөлөөтэй, хараат бусаар дамжуулах хэрэгсэл хараахан гараагүй байна, үүний шалтгаан нь хэвлэлүүд аль нэг нам, эвсэл, байгууллагад харьяалагддаг учир бие дааж чадахгүй байна гэж тайлбарлажээ. Мөн “Бид сониндоо “ӨНӨӨДӨР” гэж нэр өглөө. Ертөнцийн мөнхийг илтгэсэн өчигдөр, өнөөдөр, маргааш хэмээх гурван цаг хоорондоо салшгүй боловч бид эндээс чухам өнөөдрийг илүү товойлгон өнөөдрийн хүмүүст өнөөдрийн мэдээллийг үнэн зөв шуурхай хүргэхийг чармайх болно”<sup>13</sup> гэж сонинхоо нэрийн учрыг тус өгүүлэлд тайлбарласан байна. Баабарын энэ сонин хувьцаа гаргах зэргээр шинэлэг менежмент хийх гэж нэлээд оролдсон ч амжилт ололгүй байсаар удалгүй хаалгаа барьжээ.

Төд удалгүй өөр нэгэн "Өнөөдөр" сонин гарч ирсэн нь нэрт сэтгүүлч Ц.Балдоржийн үүсгэн байгуулсан үндэсний өдөр тутмын хэвлэл юм. 1996 оны 9-р сарын 18-нд дөнгөж байгуулагдсан "Монгол ньюс" ХХК-ийн ерөнхий захирал Ц.Балдорж "МН-Өнөөдөр" сониныг үүсгэн байгуулах тухай 01 тоот тушаал гаргасан байна.

"Тус компани нь сонин хэвлэлийн үйл ажиллагаа явуулах болсонтой холбогдуулан "Монгол ньюс-Өнөөдөр" өдөр тутмын мэдээллийн сониныг бий болгохоор шийдвэрлэв. "Монгол ньюс-Өнөөдөр" сонины ерөнхий редактораар Б.Галааридыг томилж, уг сониныг улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг хариуцахыг даалгав. Ерөнхий захирал Ц.Балдорж<sup>14</sup> гэсэн баримт тус сониныхон 10 жилийн ойгоороо хэвлүүлсэн номд байгаа нь Монголын орчин цагийн сэтгүүл зүйн нэгэн чухал салаа мөчир болох өдөр тутмын сонинуудын түүхнээ цоо шинээр шан татсан үйл явдлыг гэрчлэх баримт юм.

**Н**эгэн зууныг элээгээд буй Монголын сэтгүүл зүйн түүхийн хамгийн арвин баялаг түүхтэй онцгой мөчлөг болох 1990-ээд оны эхэн үеийн зарим нэгэн баримтыг мөшгөн тодлоход ийм байна. Үйл явдал нь шинэ сэргэг, цаг хугацаа нь ойр дөхүү, гэрч оролцогсод нь энх тунх дээр нь тодлон түүхчлэх нь нэн эрхэм болой.

### Ишлэл

<sup>1</sup> Галаарид Б. Чөлөөт хэвлэлийн үзэл санаа Монголд дэлгэрсэн нь // [galaarid.blogspot.com/2013/05/blog-post.html](http://galaarid.blogspot.com/2013/05/blog-post.html)

<sup>2</sup> Түдэв Л. Он цагийн мэдээ // Бүтээлийн чуулган. ХХХ боть, УБ., 420 дахь тал.

<sup>3</sup> Сэтгүүлч Нанж.Лхагва // Б.Галааридын хувийн архив. Ярианы тэмдэглэл №905.

<sup>4</sup> Амарсанаа С. 2011. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. УБ., 98 дахь тал.

<sup>5</sup> Дарь.Сүхбаатарын захидал // Б.Галааридын хувийн архив. Баримт №1021.

<sup>6</sup> Оюунчимэг Т. 2011. Миний хүссэн ардчилал биш. УБ., 21 дэх тал.

<sup>7</sup> Баасансүрэн Т. 2009. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. УБ., 37 дахь тал.

<sup>8</sup> Амарсанаа С. 2011. Дурд. зох., 212 дахь тал.

<sup>9</sup> Баасансүрэн Т. 2009. Дурд. зох., 495 дахь тал.

<sup>10</sup> Амарсанаа С. 2011. Дурд. зох., 207 дахь тал.

<sup>11</sup> "Уншигч Танаа" өгүүлэл // "Хүмүүн" сонин. 1990.08.11. №1 (154).

<sup>12</sup> Мягмарсамбуу Ш. "Сайн байна уу? Та" өгүүлэл // "Сайн байна уу?" сонин. №01, 1992 оны 3-р сар.

<sup>13</sup> Баабар Б. "Уншигч танд учирлах нь" өгүүлэл // "Өнөөдөр" сонин. 1992.10.06. №1.

<sup>14</sup> Чулуун Р. 2006. "Өнөөдөр". Арван жилийн түүхэн товъёог. УБ., 7 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амарсанаа С. 2011. Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд. УБ., 98 дахь тал.

2. Баасансүрэн Т. 2009. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. УБ., 37 дахь тал.

3. Галаарид Б. Чөлөөт хэвлэлийн үзэл санаа Монголд дэлгэрсэн нь // [galaarid.blogspot.com/2013/05/blog-post.html](http://galaarid.blogspot.com/2013/05/blog-post.html)

4. Оюунчимэг Т. 2011. Миний хүссэн ардчилал биш. УБ., 21 дэх тал.

5. Түдэв Л. Он цагийн мэдээ // Бүтээлийн чуулган. ХХХ боть, УБ., 420 дахь тал.

6. Чулуун Р. 2006. "Өнөөдөр". Арван жилийн түүхэн товъёог. УБ., 7 дахь тал.